




МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ





МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Улаанбаатар хот

2020 он



Энэхүү гарын авлагыг "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд боловсруулав.

Монголбанкны зөвшөөрөлгүйгээр товхимлыг цахим болон хэвлэмэл байдлаар, бүтнээр, эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.

© Монголбанк

Үнэгүй тараагдана.



Мөнгө угаах гэж юу вэ?





Мөнгө угаах үйл ажиллагаа гэдэг нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг буюу хууль бус эх үүсвэрийг нуун дарагдуулахын тулд төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглан хэлбэр, төрхийг нь хувиргаж, эзэмшигчийг нь өөрчлөн хууль ёсны хөрөнгө, орлого мэт харагдуулах үйл ажиллагаа юм.



Зураг 1. Мөнгө угаах гэмт хэргийн үе шатууд



Олон улсын стандартад мөнгө угаах үйлдлийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

-  Эд хөрөнгийг гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж тухайн эд хөрөнгийн эх үүсвэрийг өөрчлөх буюу шилжүүлэх;
-  Эд хөрөнгийг гэмт хэргийн орлого гэдгийг мэдсээр байж тухайн эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга болон эд хөрөнгийн эрхийг шилжүүлэх, нуух, далдлах;
-  Эд хөрөнгийг олж авахдаа гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг нь мэдсээр байж тухайн эд хөрөнгийг олж авах, эзэмших, ашиглах;
-  Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, үгсэн тохиролцох, үйлдэхийг завдах, хамжих, хатгах, туслах болон зөвлөгөө өгөх.

1. Байршуулах үе шат:

Гэмт хэргийн замаар олсон орлого, хөрөнгийг хууль ёсны болгож санхүүгийн системд байршуулах, мөнгөн тэмдэгтийг өөр дэвсгэрт, гадаад валютаар солиулах, бэлэн мөнгийг тээвэрлэх эсвэл банкны дансанд байршуулах гэх мэт.



2. Нуун далдлах үе шат:

Хууль бус, гэмт хэргийн гаралтай хөрөнгө, орлогын гарал үүслийг нуун дарагдуулах зорилгоор бэлэн бус шилжүүлэг хийх, өөр банкны дансанд байршуулах, банк хооронд хувааж, нийлүүлж шилжүүлэх, олон банк санхүүгийн байгууллага, улс орнуудаар дамжуулан эх үүсвэрийг нуун далдлах гэх мэт.



3. Буцаан төвлөрүүлэх үе шат:

Нэгэнт гарал үүслийг нь тогтооход хүндрэлтэй болсон эсхүл хууль ёсны мэт харагдуулсан мөнгөө буцаан өөрийн нэр дээр төвлөрүүлэх.

Зураг 2. Мөнгө угаах гэмт хэргийн үе шатууд



Мөнгө угаах үйл ажиллагаанд санхүүгийн салбарын нарийн мэргэшсэн мэргэжилтнүүдээс гадна хувь хүн, хуулийн этгээд, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, Хуульч, Нотариатч, Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч) нар нь халхавч компани болон зуучлагч ашиглаж үйл ажиллагаа явуулах, гүйлгээ хийх нь түгээмэл байдаг. Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус хөрөнгө, орлогыг илрүүлэхэд олон салбарыг хамарсан өргөн хүрээний мэдлэг шаардлагатай болдог. Мөнгө угаагчид гэмт хэргийн замаар олсон хөрөнгөө олон улсын болон дотоодын зах зээл дээр ашиглагдаж байгаа төлбөр тооцооны хэрэгслүүд болон өндөр өртөгтэй хөрвөх чадвартай үнэт металл, үнэт эдлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглан хэлбэр, төрхийг нь хувиргахыг оролддог.

Терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ?

Терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь террорист үйл ажиллагаа үйлдэхээр санаархаж, төлөвлөж эсхүл оролцохоор төлөвлөж байгаа хүн, байгууллага болон бусад этгээдэд зориулан хууль ёсны болон хууль бус хөрөнгө, орлогыг хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулах үйл ажиллагаа юм. Террорист үйл ажиллагааг ихэвчлэн дараах эх үүсвэрээс олсон орлогоор санхүүжүүлдэг. Үүнд:



Луйвар, залилан хийх



Хар тамхи, зэвсгийн наймааны хууль бус худалдаа явуулах



Ашгийн бус байгууллагыг урвуулан ашиглах



Хүн барьцаалах, хулгайлах



Цахим мөнгөөр хууль бус худалдаа хийх




Газрын тос, нүүрс, алмааз, алт зэрэг бараагаар хууль бус худалдаа хийх

..... Зураг 3. Террорист үйл ажиллагааг санхүүжүүлэгч нийтлэг эх үүсвэрүүд



Зураг 4. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг







Зураг 5. Мөнгө угаах гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн ялгаа



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн талаар бид яагаад мэдэх ёстой вэ?


Иргэн таны хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэхийн тулд энэ төрлийн гэмт хэрэг гэж юуг хэлдэг, ямар арга хэлбэрээр явагддаг, ямар эрх зүйн зохицуулалтууд үйлчилдэг талаар мэдлэг мэдээлэлтэй байх хэрэгтэй. Ингэж чадсанаар та өөрийгөө болон бусдыг гэмт хэрэгт холбогдохоос хамгаалах болно.

Иргэд санамсаргүйгээр энэхүү төрлийн гэмт хэргийн золиос болдог жишээнүүдээс дурдвал:

-  Бусдын хүсэлтээр Улсын хилээр бэлэн мөнгө, эд бараа тээвэрлэх
-  Бусдад хувийн мэдээллээ алдах
-  Бусдад өөрийн бичиг баримтыг хэрэглүүлэх боломж олгох
-  Бусдад өөрийн дансыг ашиглуулах боломж олгох.

Улс орны хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь эдийн засаг, нийгэмд ихээхэн сөрөг үр дагавартай. Хууль бус их хэмжээний мөнгө эдийн засагт орж ирээд буцаад гарах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг алдагдуулаад зогсохгүй хямралд ч хүргэж болзошгүй юм. Үүний зэрэгцээ олон улсад дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, гадны орнууд дотоодын банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, дотоодын банк, санхүүгийн байгууллагуудтай харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээг авч болох юм. Хууль бус мөнгө дотоодынх бол энэ нь хээл хахууль, авилгыг дэмжиж, шударга өрсөлдөөнийг үгүй хийх, шударга бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монопол байдал бий болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо сул хөгжсөн орнуудыг мөнгө угаагчид ашиглах нь их байдаг.

Монгол Улсад гарч байгаа мөнгө угаах гэмт хэрэг нь ихэвчлэн дараах аргаар үйлдэгдэж байгаа тул иргэн та энэ гэмт хэргийн талаар мэдлэгтэй байж урьдчилан сэргийлээрэй. Энэхүү төрлийн гэмт хэргийн ял, шийтгэл өндөр байдаг тул мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай санхүүгийн боловсролоо дээшлүүлэх нь чухал юм.



Гэмт хэрэгтнүүд өөрсдийн гэр бүл, эцэг эх, ах дүү, хамаатан садан, ойр дотны хүн эсвэл гуравдагч этгээдийн гадаад, дотоодын банканд дахь данс руу гэмт хэргийн замаар олсон орлогоо шилжүүлэх

Үнэт металл худалдан авч, хууль бусаар Монгол Улсын хилээр гарган, эргэлтэд оруулах

Улс төрд нөлөө бүхий этгээдүүд албан тушаалаа урвуулан ашиглаж, хээл хахуулийн замаар олсон хууль бус орлогоо гадаад, дотоодын банк санхүүгийн байгууллагаар дамжуулан хууль ёсны мэт болгохыг оролдох

Төрийн өмчит компанийн удирдлагад ажиллаж байсан зарим албан хаагчид албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хуурамч гэрээ байгуулан хөрөнгө мөнгийг гадаадын хэд хэдэн улс руу гарган, буцааж оруулж ирэх

Хууль бус их хэмжээний орлогоо богино хугацаанд бага дүнтэй олон шилжүүлэг болгон шилжүүлж, эх үүсвэрийг нь далдлах

Нягтлан бодогч, хуульч, нотариатч, санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нарыг хөлслөн мэргэжлийн зөвлөгөө авах замаар хууль бус хөрөнгө, орлогоо хууль ёсны мэт харагдуулах



Мөнгө угаах гэмт хэргийн талаарх үндэсний эрх зүйн зохицуулалт

Улсын Их Хурлаар 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталснаар Монголбанкны дэргэд Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ыг байгуулж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлсэн.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2018 болон 2019 онуудад нэмэлт өөрчлөлт оруулснаар хуулийн хамрах хүрээг өргөжүүлж, олон улсын стандарт, шаардлагын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдийн төрлийг нэмэгдүүлсэн. Ингэснээр дараах мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээж байна.

Иргэн та дараах төрлийн байгууллагуудаар үйлчлүүлж байгаа бол тухайн байгууллагуудын шаардаж байгаа мэдээлэл болон баримт бичгийг гаргаж өгөх үүрэгтэй. Үүнд:



Банк



Банк бус санхүүгийн байгууллага



Даатгагч болон даатгалын мөргөжлийн оролцогч



Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани



Үнэт цаасны зах зээлд оролцогч мөргөжлийн байгууллага



Хадгаламж, зээлийн хоршоо



Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч



Нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч



Хэрэв та эдгээр байгууллагын шаардсан мэдээлэл болон баримт бичгийг гаргаж өгөхөөс татгалзвал дээрх мэдээлэх үүрэгтэй этгээдүүд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.4-т зааснаар танд үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

Хэрвээ дээрх мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг зөрчвөл Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлд зааснаар:

Харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүргээ биелүүлээгүй бол

Шилжүүлэг хийх, хүлээн авах, дамжуулахдаа шилжүүлэгч, хүлээн авагчийн талаарх хуульд заасан мэдээллийг бүрэн агуулаагүй байхад шилжүүлэг хийсэн, хүлээн авсан, эсхүл дамжуулсан бол

Хуульд заасны дагуу харилцагчийг таньж мэдэх хүрээнд шаардсан мэдээллийг өгөхөөс татгалзсан хүн, хуулийн этгээдэд аливаа үйлчилгээ үзүүлсэн бол

Эрсдэл өндөртэй улс орны иргэн, хуулийн этгээд, Улс төрд нөлөө бүхий этгээдүүд гэх зэрэг харилцагчийг өндөр эрсдэлтэй гэж авч үзэн таних ажиллагаа хийгээгүй бол

Зөрчилтэй гүйлгээний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хураалгаж, хувь хүнийг 1,000-3,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 10,000-30,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгуулна.

Иймд та өөрийн иргэний үүргээ биелүүлж, эдгээр байгууллагаас үйлчилгээ авах гэж байгаа бол хуулийн дагуу шаардсан мэдээлэл болон бичиг баримтыг гаргаж өгөх үүрэгтэй. Ингэснээр та өөрийгөө мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахаас зайлсхийх боломжтой юм.

Иргэн та санаатай болон санамсаргүйгээр энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор санхүүгийн боловсролоо дээшлүүлж байх нь чухал юм.



Монгол Улсын Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд зааснаар:

“Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол”:

6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Гэмт хэргийг байнга тогтвортой үйлдэх, албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол 1 жилээс 5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зохион байгуулалттай гэмт хэрэг үйлдсэн бол 5 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.



Та 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол Гаалийн байгууллагад үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

Худал мэдүүлсэн тохиолдолд зөрчилтэй төлбөрийн хэрэгслийг хураан авч, хураан авсан мөнгөн дүнгийн 15 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.




Хэрвээ танд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл байгаа бол хэнд хандах вэ?

Танд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой гэж үзэж байгаа мэдээлэл байвал дараах зохицуулах болон хууль сахиулах байгууллагуудад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Зохицуулах байгууллагууд	Холбоо барих
Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба	Утас: +(976) 11 326161, 11 323434 Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Бага тойруу-3, 15160 Цахим шуудан: fiuforpublic@mongolbank.mn
Санхүүгийн зохицуулах хорооны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх алба	Утас: +(976)-51-264444 +(976)-70137047 (МУТСТ алба) Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр, 15160 Цахим шуудан: info@frc.mn

Хууль сахиулах байгууллагууд	Холбоо барих
Цагдаагийн ерөнхий газар	Утас: +(976)-51-265734, +(976)-51-265794 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо Самбуугийн гудамж-18. Эрүүгийн цагдаагийн алба.
Тагнуулын ерөнхий газар	Утас: +(976)-92263017 Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчны гудамж-3 Цахим шуудан: amlcft@gia.gov.mn; nctcc@gia.gov.mn
Авлигатай тэмцэх газар	Утас: +(976)-110 (Үнэ төлбөргүй) Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороолол, Сөүлийн гудамж, 41 Цахим шуудан: contact@iaac.mn



Төсөвчин




on GooglePlay



on App Store

Энэхүү аапликейшн нь өөртөө хуримтлал тооцоологч, хадгалагч, зээл тооцоологч, ипотек, төсөвлөгч зэрэг тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn



 /mongolbank.mn

 /Санхүүгийн боловсрол

 /@mongolbank_mn

 www.mongolbank.mn

 /Mongolbankmn

 info@mongolbank.mn

 11 310081